

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслийн байршил	3
1.3. Төслийн нөөц хүчин чадал	5
1.4. Ажиллах горим.....	5
1.5. Хүний нөөц.....	6
1.6. “Овоот” барилгын чулууны ордын бүтээгдэхүүн гаргалт.....	6
1.7. Төслийн дэд бүтэц.....	9
1.7.1. Усан хангамж.....	9
1.7.2. Цахилгаан хангамж.....	9
1.7.3. Хог хаягдал.....	9
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	13
3.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ.....	13
3.1.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ.....	13
3.1.2. Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	14
3.2. Агаар түүний чанарт үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ.....	16
3.2.1. Төсөл агаарын чанарт нөлөөлөл байдал, үнэлгээ.....	16
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
6. ДҮЙЦҮҮЛЭН НӨХӨН СЭРГЭЭХ , ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	27
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
ХАВСРАЛТ	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
Хүснэгт 2. ДО-002А тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол	3
Хүснэгт 3. ДО-002А тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах нөөцийн нэгдсэн хүснэгт	5
Хүснэгт 4. Жилд ажиллах хугацаа	6
Хүснэгт 5. Жилд ажиллах хугацаа	6
Хүснэгт 6. Бутлах цехийн ажиллах горим	7
Хүснэгт 7. Бутлах цехийн цагийн хүчин чадал	7
Хүснэгт 8. Хотхоны усны хэрэглээ	9
Хүснэгт 9. Ил уурхайн усны хэрэглээ	9
Хүснэгт 10. Ахуйн хог хаягдлын хэмжээ	9
Хүснэгт 11. Ашиглалтын 1 жилд машин механизмаас гарах хорт хийн хэмжээ.....	10
Хүснэгт 12. Машин механизмаас гарах хаягдал тос маслын хэмжээ.....	10
Хүснэгт 13. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт.....	13
Хүснэгт 14. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	15
Хүснэгт 15. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	18
Хүснэгт 16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
Хүснэгт 17. Дүйцүүлэн нөхөн сэргээх, орчны хяналт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	23
Хүснэгт 18. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 19. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт 20. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	27
Хүснэгт 22.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	29
Хүснэгт 23. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Овоот” нэртэй талбайн байршлын зураг	4
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал	4
Зураг 3. Уурхайн хүний нөөцийн бүтэц.....	6
Зураг 4. Бутлах үйлдвэрийн технологийн схем	7
Зураг 5. Бутлах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем.....	8
Зураг 6. Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	15
Зураг 7. Тоосонцорын аэродинамик хэмжээ, мкм.....	17

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт №1. Төслийн ерөнхий мэдээлэл

1	Төслийн нэр:	Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг “Овоот” нэртэй ордыг ил аргаар ашиглах төсөл
2	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	“ДОЦ” ХХК нь Монгол улсын 0711001112 тоот бүртгэлийн дугаар, 2011506 регистрийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.
3	Төсөл хэрэгжүүлэгчийн тусгай зөвшөөрөл:	Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Овоот” нэртэй, MV-21000063 (ДО-002А) дугаар бүхий 26.67 га талбайтай ашиглалтын тусгай зөвшөөрлийг Дорнод аймгийн Засаг дарга 2019 оны 03-р сарын 04-ний өдөр 0711001112 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй “ДОЦ” ХХК-д олгосон болно.
4	Төслийн талбайн хэмжээ:	26.67 га
5	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Дорнод аймаг, Хэрлэн сум, 6-р баг, <i>Оффис байр</i>

1.2. Төслийн байршил


“Овоот” нэртэй талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 650 км-т Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт Чойбалсан хотоос баруун тийш 7.5 км-т Хэрлэн голын хойд талд 803.0 тоот өндөрлөгтэй Овоот уулаас Зүүн хойш 70 хэмээр 500 метр зайд М-50-133 хавтгайд байрлана.

- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48-10
-

Газарзүйн солбицол

Хүснэгт №2. ДО-002А тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	114° 25' 05.53”	48° 02' 58.81”
2	114° 25' 25.64”	48° 02' 58.81”
3	114° 25' 25.64”	48° 03' 19.52”
4	114° 25' 05.53”	48° 03' 19.52”



Зураг №1. “Овоот” нэртэй талбайн байршлын зураг



Зураг №2. Төслийн талбайн харагдах байдал

1.3. Төслийн нөөц, хүчин чадал

Ил уурхайн хүчин чадал: “Овоот” нэртэй барилгын чулууны ордыг ашиглах ил уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагын саналыг үндэслэн жилд 40.0 мян.м3 барилгын чулуу олборлохоор тусгалаа. Нийт үйлдвэрлэлийн нөөцийг олборлоход 56 жил шаардлагатай ба төсөлд эхний 10 жилийн нарийвчилсан судалгаа болон батлагдсан нөөц буюу ордын хэмжээнд эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн.

Ордын нөөц: Геологийн тогтцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ “Овоот” барилгын чулууны орд нь “Барилгын чулууны ордод нөөцийн ангилал хэрэглэх заавар”-ын дагуу II-р бүлгийн ордод хамаарах ба ийм орд ашигт малтмалын зузаан ба чанараар тогтвортой, хэмжээний хувьд дунд ба бага орд байна.

Ордын нөөцийг бодитой зэргээр тооцоолсон бөгөөд бодитой (В) 2,236,879.15 м3 нөөцийг Бл-В гэсэн блокоор тооцоолсон байна.

Хүснэгт №3. ДО-002А тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдах нөөцийн нэгдсэн хүснэгт

№	Нөөцийн блокийн дугаар ба нөөцийн зэрэглэл	Блокийн талбай, м ²	Хуулах хөрсний дундаж зузаан /м/	Ашигт малтм алын дунда ж зузаа н /м/	Хуулах хөрсний эзлэхүүн /м ³ /	Ашигт малтмалын нөөц /м ³ /	Хуулах хөрсний эзлэхүүн ба ашигт малтмалын эзлэхүүний харьцаа
1	Бл-В	159,891.2 9	1.1	13.99	175,880.42	2,236,879.15	01:12.7
Ордын хэмжээнд бүгд:							
Бодитой (В) нөөц							
	Бодитой нөөц /В/	159,891.2 9	1.1	13.99	175,880.42	2,236,879.15	01:12.7

Ил уурхайн ашиглах технологи:

Тухайн ордын уул геологийн нөхцөлд тохирох технологийг сонгон хэрэгжүүлж, зохион байгуулалтын хувьд бэрхшээлгүй үйлдвэрлэл явуулан, эдийн засгийн үр өгөөжийг хангахад ашигт малтмалын ордыг ашиглах аргын үндсэн зорилго чиглэдэг.

Уг ордын олборлолтын ажлыг ил уурхайн аргаар явуулах нь хамгийн үр дүнтэй юм. Учир нь В зэрэглэлийн нөөц нь 13.5-15.0 м гүнд нөөц бодогдсон ба уул-техникийн нөхцөл болон бусад хүчин зүйлээс харгалзан үзэхэд ил аргаар ашиглахад эдийн засгийн хувьд үр ашигтай байна.

Ордын барилгын чулууны биетийн тогтоц, хөрсний зузаан, газар зүйн байрлал, хөрсний чулуулгийн шинж чанар зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр уг ил уурхайг тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар сонгов.

1.4. Ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний хугацаанаас хамааруулан жилд 3-р сарын 21-аас 10-р сарын 31-ыг дуустал ажиллана. Уурхайн ажиллах хоногийг дараах байдлаар тооцоолов. Үүнд:

Хүснэгт №4. Жилд ажиллах хугацаа

Хоног, зориулалт	Ажиллах сарууд	Жилд
------------------	----------------	------

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ОВООТ” ДО-002 ТООТ ТҮГЭЭМЭЛ
ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**


	3	4	5	6	7	8	9	10	
Хуанлийн	10	30	31	30	31	31	30	31	224
Баяр ёслол				2	3				5
Бусад	1	2	2	1	1	2	3	2	14
Ажлын өдөр	9	28	29	27	27	29	27	29	205

Хүснэгт №5. Жилд ажиллах хугацаа

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	224
2	Баяр ёслол	хоног	5
3	Амралт, засвар үйлчилгээ	хоног	14
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	205.0
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	24
6	Ээлжийн тоо	ш	2.0
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	8
8	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх)	цаг	2
9	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	цаг	1
10	Өдрийн сул зогсолт	цаг	1.0
11	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	20
12	Цаг ашиглалт		0.83
13	Жилд ажиллах нийт цаг	цаг	4093

Ил уурхай долоо хоногт амралтгүй 8 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр мөн бутлах хэсэг нь 10 цагаар 2 ээлжээр ажиллана. Цаг ашиглалтын нормативд итгэлцүүр 0.83 байхаар тооцов.

1.5. Хүний нөөц




Зураг №3. Уурхайн хүний нөөцийн бүтэц

1.6. “Овоот” барилгын чулууны ордын бүтээгдэхүүн гаргалт

Ил уурхайгаас бутлах хэсэгт ирэх барилгын чулууг (барилгын чулууны хамгийн том хэмжээ 300 мм) хүлээн авах бункерт, утгуурт ачигчаар асгалт хийнэ. Барилгын чулууны бункерээс GZD800-1800 маркийн чичиргээт тэжээгүүрийн тусламжтайгаар PE400*600 маркийн хацарт бутлуурт бутлагдана. Бутлалтаас гарсан бүтээгдэхүүн нь туузан конвейороор дамжин II шатны PYZ-600 маркийн конусан бутлуурт бутлагдана. Бутлагдсан барилгын чулуу нь SZZ0918 маркийн чичиргээт шигшүүрт орох ба 0-5, 5-10, 10-20 мм гэсэн ширхэглэлтэй бүтээгдэхүүн гарна. +20 мм ширхэгтэй хэсэг нь II шатны бутлуур луу орж цикл давтагдана.

“Овоот”-ын хэсгийн барилгын чулууны ордын дайрга, элс үйлдвэрлэх технологийн схемийг зурагт үзүүлэв.



Зураг №4. Бутлах үйлдвэрийн технологийн схем

Хүснэгт №6. Бутлах цехийн ажиллах горим


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	224
2	Баяр ёслол	хоног	5
3	Амралт, засвар үйлчилгээ	хоног	14
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	205
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	20
6	Ээлжийн тоо	ш	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	10
8	Цаг ашиглалт		0.85
9	Жилд ажиллах нийт цаг	цаг	3485

Барилгын чулууг бутлах цех нь бутлах, шигших гэсэн үндсэн шат дамжлагуудаас бүрдэх бөгөөд цехийн хүчин чадлыг ажиллах горимоос нь хамааруулан тооцоолов.

Хүснэгт №7. Бутлах цехийн цагийн хүчин чадал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Qж Барилгын чулуу бутлах цехийн жилийн хүчин чадал	мян.м3	40
2	Qж Барилгын чулуу бутлах цехийн жилийн хүчин чадал	мян.тн	101.6
3	N Жилд ажиллах хоногийн тоо	хоног	205
4	n Нэг ээлжинд ажиллах цаг	цаг	10
5	m Хоногт ажиллах ээлжийн тоо	ш	2
6	K3 Тоног төхөөрөмжийн цаг ашиглалтын коэффициент		0.85
7	Qц Цагийн хүчин чадал	тн	29.15

Дээрх томьёоны дагуу бутлах цех нь цагт 29.15 тн барилгын чулуу бутлахаар тооцоологдож байна.



Зураг №5. Бутлах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем

1.7. Төслийн дэд бүтэц

1.7.1. Усан хангамж: Зам усалгааны усыг Чойбалсан хотоос авч хангахаас гадна ундны усаа цэвэр усны үйлдвэрээс 18.9 литрийн баллонтой ус зөөж хэргэлэнэ.

Уурхайн үндсэн ус хэрэглээ нь унд ахуйн болон зам, талбайн усалгаа байх ба технологийн хэрэгцээнд ямар нэг хэлбэрээр ашиглагдахгүй юм. Иймд, тус уурхайн ус хэрэглээг дараах байдлаар тооцов.

Хотхоны усны хэрэглээ

Уурхайн хотхонд нэг дор байрлах ажилчдын тоо нь уурхайн үйлдвэрийн ажилчид болон удирдах албан тушаалтнууд нийтдээ 23 хүн байрлан ажиллахаар тусгасан. Нэг хүний хоногийн усны хэрэглээг 50 литр байхаар тооцлоо. Ундны усны нийт хэрэглээ хоногт 1.1 м³, жилд 0.26 мян.м³ байна.

Хүснэгт № 8. Хотхоны усны хэрэглээ

Норм, л/хоног	Хүний тоо, ш	Цэвэр усны хэрэглээ	
		м ³ /хоног	мян.м ³ /жил
50	23	1.15	0.24

Ил уурхайн зам усалгааны усны хэрэглээ

Зам усалгааны усыг хэрлэн голоос авч хангахаар төлөвлөсөн. Уурхайн үйл ажиллагаа гадаад тээврийн усалгаа, тоосжилтын эсрэг авах арга хэмжээний усыг тооцож төлөвлөсөн. Энэ ажилд хоногт 16.4 м³ ус шаардлагатай байна.

Хүснэгт №9. Ил уурхайн усны хэрэглээ

№	Хэрэглэгчийн нэр	Цэвэр усны хэрэглээ			
		Мян.м ³ /жил	м ³ /хоног	м ³ /цаг	л/сек
1	Техникийн зам усалгаа	1.96	15	0.63	0.174
	Нийт		15	0.63	0.174

Жилд унд ахуйн хэрэгцээнд 0.24 мян.м³, зам талбайн усалгаанд 1.96 мян.м³ нийтдээ 2.2 мян.м³ цэвэр ус зарцуулахаар байна.

1.7.2. Цахилгаан хангамж: “Доц” ХХК нь Овоот нэртэй барилгын чулууны ордын цахилгааны эх үүсвэрийг Чойбалсан хотоос Баянтүмэн сумын хоорондох 6 кВ-ын агаарын шугамаас бууруулж 380 В-ийн 2 км урт ЦДАШ татсан байна.

1.7.3. Хог хаягдал:

Тухайн ордыг ашиглах, олборлолт явуулах үйл ажиллагаанаас байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц хатуу, шингэн хог хаягдал гарахгүй. Олборлолтын явцад газрын хэвлийгээс гаргасан хөрс болон чулуулгийг эргүүлэн ухсан нүхийг дарах, нөхөн сэргээхэд ашиглах тул үүнийг хог хаягдал хэмээн үзэхгүй.

Хүснэгт №10. Ахуйн хог хаягдлын хэмжээ

Он	Нийт хоног	ажиллах	Ахуйн хог хаягдал 0,3кг	Ажилчдын тоо	Нийт
Нэг жилд	205		0,3	52	3198 кг
Нийт /5 жилээр/					15990 кг

Хүснэгтээс харахад эхний 5 жилд ойролцоогоор 15 тн ахуйн зориулалттай хог хаягдал гарахаар байна. Хөрс хуулалтын явцад хөрсний овоолго хийж, уурхайн нөхөн сэргээлтийг байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу хийх шаардлагатай бөгөөд техникийн нөхөн сэргээлтийн үед хаягдал чулуулгийг газрын гүнд булах шаардлагатай. Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ тусгай зориулалтын тагтай саванд хадгалж байгаад тээвэрлэн сумын захиргаатай гэрээ байгуулан тогтмол хугацаанд заасан хогийн цэгт зайлуулна.

Хийн хаягдал

Хүснэгт №11. Ашиглалтын 1 жилд машин механизмаас гарах хорт хийн хэмжээ

Уурхайн машин, механизм	Түлш	CO кг	NO2 кг	Нүүрстөрөгч	SO2
Экскаватор Hyundai 290LC	42,874	4.2	1.7	1.2	0.8
Утгуурт ачигч /ZL-50/	34,122	3.4	1.3	1.0	0.6
Автосамосвал/HOWO/	3,758	0.3	0.12	0.11	0.07

Шингэн хаягдал

Тус уурхайн ажилчдын тосгонд байрлах ашиглалтын талбайд бие засах газар, бохирын цооног байгуулах бөгөөд энэ нэгдсэн цэгт хаяж байх нь зүйтэй.

Мөн бидний зүгээс бага оврын цэвэрлэх байгууламж бий болгох саналыг тавьж байна.

Уурхайн үйл ажиллагааны явцад хөрсийг нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байхад онцгой анхаарах ба аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахина.

Хүснэгт №12. Машин механизмаас гарах хаягдал тос маслын хэмжээ

Тоног төхөөрөмжийн нэрс	Тос,масло солих жилд	Тоног төхөөрөмжийн тоо/ш/	Нэг удаа солиход/л/	Жилд нийт/л/
Экскаватор Hyundai 290LC	2	1	25	50
Утгуурт ачигч /ZL-50/	2	1	25	50
Автосамосвал/HOWO/	2	2	56	112
Усны машин	2	1	12	24
Түлшний машин	2	1	12	24
Үйлчилгээний машин	2	1	4	8
Нийт				268

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уур амьсгал: Уур амьсгалын мужын хувьд дулаан зунтай чийглэг мужид багтах бөгөөд цас багатай ширүүвтэр өвөлтэй дэд мужид багтана. Бүх нутгаар агаарын хэм харьцангуй жигд тархалттай байдаг. Элсэрхэг гадаргуутай тул наранд халж агаарын хэмийг нэлээд дээшлүүлдэг. Жилийн хамгийн хүйтэн хугацаа нь 1-2-р сарууд бөгөөд эдгээр саруудад агаарын температур нь -20 -25°C хүрэх ба зарим тохиолдолд хааяа -40°C , хамгийн дулаан нь 7-р сард $+25$ -30°C заримдаа $+35^{\circ}\text{C}$ хүрнэ. Хөрсний хөлдөлтийн гүн нь дунджаар 1.5-2.5 м-т хэлбэлзэнэ.

Сумын нутгийн нарны нийлбэр цацрагийн жилийн дундаж хэмжээ нь 1300-1400 кВт-цаг/м². Жилийн бүрхэг өдрийн тоо 50 хоног, цэлмэг өдрийн тоо 120 хоног үргэлжилдэг. Нэг жилд нар гийгүүлэх дундаж хугацаа нь 2900-3000 цаг байдаг. Агаарын жилийн дундаж даралт 844 гПа, салхигүй өдрийн тоо 51 хоног, салхины хамгийн их хурд нь 38 м/сек байна. Нэг ба долоодугаар сарын агаарын даралт нь 842-844 гПа юм. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нийт нутгаар 200-250 мм байдаг.

Геологийн тогтоц: Дорнодын бүс нутаг буюу Улз-Хэрлэнгийн сав газрын анх төрмөлийн түрүү болон хожуу үеийн түүхийг сэргээн тодруулахад нэн төвөгтэй. Тухайн нутагт эл үеийн геологийн тогтоц хурдас чулуулгийн найрлага бүрдэл нь кембрийн өмнөх түрүү үед геосинклинал горимт геологийн хөгжил зонхилж байсныг сэргээх боломжтой. Энэ нутгийн геосинклинал хөгжил нь бодвол кембрийн түрүү үе хүртэл үргэлжлэн улмаар эрчимт атираат бүс болон хувирахдаа магмын үйл ажиллагаанд идэвхтэй өртөгдсөн болох нь хурдас чулуулгийн өгөршил хувиралт нь ногоон чулуут буюу амфиболит зэргэмжийн төрхшилд хүрсэн явдал гэрчилж байна. Энэхүү ягир атираат бүтцийн дэвсгэр дээр түрүү девоны галавт ахин геосинклинал горим Монгол–Агнуурын атираат муж хэмээх хүрээнд тогтоосон билээ.

Хөрсөн бүрхэвч: Хөрс-газарзүйн мужлалаар говийн их муж багтах бөгөөд цөлийн бор саарал хөрсний бүсийн заг сүүж-борзонгийн говийн тойрогт хамаарна. “Овоот” барилгын чулууны орд орчимд хуурай хээрийн экосистемд багтах хээрийн хөрсний бүлгийн хар хүрэн хөрс зонхилон тархсан байна. Ялзмагийн бодисын агуулмж 2,81% байгаа нь органик агууламж сайн зэргийн хөрсийг илтгэнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=7.8 буюу сул шүлтлэг орчинг үзүүлж байна. Солилцох сууриудын нийлбэр Са+Мg агууламж нь 19,0 мг-экв/100 гр хөрсөнд байгаа нь солилцох сууриудын их хангалттай зэргийн байгааг харуулж байна. Хөрсний шим тэжээлийн бодисын ихэнх нь шим ба эрдэс нэгдлийн байдлаар усанд уусахгүй хэлбэрээр байна.

Ургамлан нөмрөг: Ургамалжилтын хувьд алаг өвс, бутлаг үетэн хээрийн дагуур Монгол хэв шинж (алаг өвс-зүр өвс - сөөг, улалжит, хэвшил) зонхилно. Ургамал газар зүйн мужлалыг тодруулбал энэ нутаг нь Евро-Азийн хээрийн их мужийн дагуур-Монголын дэд их муж, дагуур –Монголын хээрийн муж, Онон-Хянган орчмын дэд мужид хамаарна. Нутгийн хойд болон өмнөд хэсгээр үетэн баялаг алаг өвс-зүр өвс тархах бөгөөд төв болон өмнөд хэсгээр алаг өвс-зүр өвс-үетэнт, алаг өвс ургадаг.

Судалгаа гүйцэтгэсэн талбай нь хээрийн бүсэд хамаарах Хялгана-жигжиг дэгнүүлт үетэн- алаг өвст бүлгэмдлээс бүрдэнэ. Ургамалжлын зүйлийн хувьд 9 овгийн 18 төрлийн нийт 22 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөглөг-1, сөөгөнцөрлөг-1, олон наст өвс-13, хоёр наст-2, нэг наст-5 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Гадаргын ус: Судалгааны талбай нь Хэрлэн голын сав газарт хамаарна. Хэрлэн голын урсгалын хурд 1м/с, Хэрлэн голын дагуу татамтай бөгөөд заримдаа 1-2 км хүрэх өргөнтэй нуга намаг элбэгтэйн дээр хуучин голдирол, салаа, татуурга, орхиол олонтой. Олон дэнж дэвсэгтэй байдаг. Их Хэнтийн нурууны өвөр бэлээс эх авч урсах Богдын гол, Цагаан гол хоёрын уулзварыг Хэрлэн голын эх гэж үзнэ. Иймд улсын хил хүртэл 1250 километр урт, ус хураах сав газрын талбай 116, 455 хавтгай дөрвөлжин километр бөгөөд усны дундаж унал километр тутамд 1,2 метр болно. Ингэхлээр Номхон далайн ай савын гол мөрний бүх талбайн 54%-ииг Хэрлэн голын усны сав эзлэх ажээ.

Газрын доорх ус: 1989-1992 онд П.Хосбаяр, Т.Биндэрьяа нарын "Эрэнцав Чойбалсангийн дүүргийн геологийн тогтоц ба ашигт малтмал" 1:200000-ны масштабтай геологийн бүлэгчилсэн зураглалын ажлын тайлан хийсэн бөгөөд энэхүү тайланд тухайн бүс нутгийн газар доорх ус хуримтлах явц, агуулагч чулуулаг тэдгээрийг геологийн хөгжлийн түүхтэй уялдуулан дүгнэх боломж бүрдсэн байдаг. Дорнод нутгийн уулс толгод хоорондын хөндий хотгор хэсгийг Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас, Палеоген, Неоген, доод Цэрдийн эх газрын нуурын том хэмхдэслэг, шаварлаг тунамал хурдас ихэвчлэн дүүргэн тогтжээ.

"Овоот" барилгын чулууны орд нь Хэрлэн голын хөндийн хойд эрэгт хадан гарш үүсгэсэн багахан өндөртэй хэрчигдмэл гадаргуутай уулсын намссан хэсэгт орших ба хайгуулын өрөмдлөг голын гольдролоос дээш төвшинд хийгдсэн тул газрын доорх ус илрээгүй, судалсан гүн хүртэл түр зуурын ба мөнхийн цэвдэг тохиолдоогүй. Энэ нь тухайн хайгуул хийсэн орд нь гадаргын хувьд тухайн райондоо өндөрлөг хэсэгт байгаатай холбоотой.

Амьтаны аймаг: Төслийн талбай нь Монгол орны амьтны газарзүйн мужлалаар Дагуурын Монголын хээрийн тойрогт (Банников,1954) хамаардаг. Эндхийн зэрлэг хөхтний зүйлийн олонхи, ялангуяа жижиг хөхтний тархац, байршлын тойм аль нэг хэмжээгээр мэдэгдэж байгаа боловч нарийвчилсан тодорхой судалгаа бага юм. Төслийн нутаг бол Төв Азийн уугуул зүйл цагаан зээрийн нопуляцийн байршил, тоо толгой, үржлийн үндсэн голомт болдог (Дуламцэрэн, 2001) онцлогтой. Шувуудын хувьд Монголын болон Азийн, дэлхийн улаан номд бүртгэгдсэн, олон улсын конвенц / CITES/ -ийн хавсралтад бүртгэгдсэн тоо толгой нь ховордож байгаа цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу, алаг тогоруу, нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг өөр хаана ч бүртгэгдээгүй **дорнын өрөвтас, халзан өрөвтас, ухаа шумбуур, хээрийн хавмгаалж, жагар хөхөө** зэрэг зүйлүүд дэлхийд ховордож байгаа **цэн тогоруу, харихараа тогоруу өвөгт тогоруунууд** өндөглөөд зусдаг. Монгол улсад 128 зүйл хөхтөн амьтан бүртгэгдсэн. Тус нутагт Хөхтөн амьтан дотор хээрийн хөхтний бүлгэмдэлд багтах Дагуур огдой, Цагаан зээр элбэг тархсан, Дагуур зурам, Орог зусаг, Дорнодын шижүүхэй, Хэргэлзэй оготно, Үлийн цагаан оготно хэвийн тархсан.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

3.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ

3.1.1. Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ

“ДОЦ” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн байршил, техник-технологийн шийдэл төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд “магадлан жагсаах” аргыг хэрэглэн үр дүнг нь доорхи хүснэгтэд илэрхийлэв.

Хүснэгт №13. Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн магадлах жагсаалт

Байгаль орчны асуудал	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын гольдролыг эвдэж, өөрчлөх	x			
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	x			
Ой модыг огтлох, гэмтээх асуудал	x			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентлогийн олдвор	x			
Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	x			
Булаг, шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	x			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцэх эсэх, түүхий эдийг олдворлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			x	
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн				x
Эрдсийг боловсруулах технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах			x	
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	x			
Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх			x	
3. Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай				
Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	x			
Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараа хөрсний элэгдэл, эвдрэл			x	
Үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			x	
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаархи төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				x
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх				x
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)				x


Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх	x				
Газар ашиглалтанд хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтанд гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх			x		
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, зардал тусгагдсан эсэх)			x		
Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаархи асуудал				x	
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)					
Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялагийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах	x				
Төслийн техник, технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				x	
Дүн	10	5	2	6	

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаах аргаах үнэлсэн үнэлгээгээр голын гольдролыг өөрчлөх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, ой модыг огтлох гэмтээх зэрэг бусад 10 асуудлаар ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байна.

Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээ, үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх гэх мэт 5 асуудлаар бага хэмжээгээр нөлөөлөл үзүүлнэ. Дунд зэрэг өртөх 2 асуудлаар нөлөөлөлтэй байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаархи төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой шаардлага хангасан зэрэг 6 асуудлаар төслөөс их нөлөөлөлтэй байна. Эдгээр асуудлуудад анхаарал хандуулах тодорхой үе шатанд зохих урьчилан сэргийлэх ажлуудыг авч байх нь зүйтэй.

3.1.2. Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Тус ордыг ашиглалтын тусгай зөвшөөрөл 26.67 га талбайг эзэмших ба ил уурхайлалтаар эвдрэлд өртөх талбай 17.8 га, бутлах хэсэг 1.14 га, уурхайн тосгон 0.6 га, шимт хөрсний овоолго 0.47 га, уурхайн зам 1.3 га, засварын газар 0.3 га, ШТС 0.06 га буюу уурхайн бүх эвдрэлд өртөх талбай 21.64 га нөлөөлөлд өртөнө. Талбайн үржил шимт хэсгийг 20 см хүртэл зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах ба уурхайг ашиглана. хүртэл зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах ба уурхайг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэнэ.



Зураг 6. Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Эдгээр газар ашиглалтын хэсгүүдэд ашиглалтын тодорхой хязгаарлалтуудыг тогтоож өгснөөр газар ашиглалтаас үүдэн гарах газрын гадаргын өөрчлөлт, газрын эвдрэл зэргийг хянах зохицуулах боломж бүрдэнэ. Тус талбайн хувьд газрын гадаргын бага зэргийн эвдрэлтэй. Энэ нь бага хэмжээний талбайд гүнзгий ухаш, хайгуулын ажлын ул мөр, тээврийн хэрэгслийн мөр зэрэг эвдрэл үүссэн байдалтай байна.

Хүснэгт №14. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Ил уурхай, овоолго, зам бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх				x	
2	Ил уурхай, овоолго, ангилан бутлах цех зэргийг байгуулахад газрын хэвлийд эвдэх				x	
3	Уурхайн хаягдал чулуулгийн овоолгоос геологи орчин, агаар, ус бохирдох		x			
4	Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх			x		
5	Гадаад дотоод тээвэрлэлт хийх автозам			x		
6	Бутлах цех ажиллах, уурхайн суурингийн объектууд, бусад агуулах зэрэгт өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах			x		

Дүгнэлт - Нийт нөлөөллийн 33.3 хувь нь их, 50 хувь нь дунд, 16.7 нь бага ангилалд багтаж байгааг үндэслэж тухайн төсөл орчны газарзүй, ландшафт, геологи орчинд газрын хэвлийд, газрын гадаргад эрчимтэй нөлөөлөл үзүүлэхээр байна гэж үзэв. Дээрх нөлөөллүүд газрын гадаргын байгалийн төрх, геологи орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд өөрчлөлт үүсгэж, техноген ландшафтын элементүүдийг буй болгоно. Хаягдлын овоолго, ил уурхайн хоосон орон зай үүсгэн цаашид байгалийн анхны төрхтэйгөөр гүйцэд нөхөн сэргээгдэхгүй учраас барилгын чулуу олборлосон талбай нь эргэлт буцалтгүй өөрчлөгдөнө.



3.2. Агаар түүний чанарт үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ

3.2.1. Төсөл агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Түгээмэл агаар бохирдуулагчын үүсэх процесс болон шинж чанар

Хүхэрлэг хий: Хүхэрлэг хий/ SO_2 / нь хүхэр агуулсан түлшний шаталтаас үүсэх бөгөөд орчныг бохирдуулагч хортой хий. Хүхэрлэг хий нь нүүрс ашигладаг дулааны цахилгаан станц, үйлдвэр, металлург, гангийн үйлдвэр, нүүрс шатаадаг ахуйн зуух, тээврийн хэрэгсэлийн түлшний шаталтаас үүснэ. Хүхэрлэг хийний хоруу чанар нь өндөр концентрацитай үед амьсгал давчдах, хоолой хорсох гэх мэт шинж тэмдэг илэрдэг бөгөөд амьсгалын замын эрхтэний системийг гэмтээдэг. $SO_2 + H_2O + O_2 \rightarrow H_2SO_4$ урвалаар томоохон хот, үйлдвэрийн бүсэд хүхэрлэг хийн өндөр концентраци нь усны ууртай нэгдэж хүчиллэг тундас (H_2SO_4) үүсгэдэг. Энэ химийн нэгдэл нь маш хүчиллэг шинжтэй бөгөөд агаарт дэгдэж борооны устай хамт газар буудаг. Хүний эрүүл мэндэд ялангуяа арьс, үсэнд хортой. Барилга байгууламжыг аажмаар элэгдүүлдэг.

Азотын давхар исэл: Азотын давхар исэл (NO_2) нь өндөр температуртай шаталтын үед дулаан шингэх урвалын үр дүнд үүсэх бөгөөд хүрээлэн байгаа орчны бохирдлын бас нэг шалтгаан юм. Гол эх үүсвэр нь тээврийн хэрэгсэлийн шатахууны шаталт, дулааны цахилгаан станц гэх мэт. Газрын гадарга дээрх озон нь азотын давхар ислийн дам бүтээгдэхүүн бөгөөд хүчтэй исэлдүүлэгч тул озоны агууламж ихэсвэл амьтан ургамалын гаднах эд эсийг гэмтээдэг. Азотын исэлүүд нь амьсгалын замын цочмог үрэвсэл, багтраа бронхит үүсгэх нөлөөтэй. Азотын ислүүд нь (NO , NO_2 , N_2O) агаарын бохирдлын химийн хувиралд гол нөлөө үзүүлдэг. Азотын (NO_x) ислүүдийн ихэнх хувийг шаталтаас үүссэн азотын исэл эзэлдэг бөгөөд шаталтаар ялгарч буй хий нь $2NO + O_2 \rightarrow 2NO_2$ (1) процессоор азотын давхар ислийг бий болгодог. Нарны гэрлийн энергийн нөлөөгөөр фотохимийн урвалын үр дүнд азотын давхар исэл NO_2 задарч сул хүчилтөрөгчийн (2) атомыг чөлөөлдөг.



Энэ чөлөөлөгдсөн хүчилтөрөгчийн атом нь гуравдагч бодис М-ийн тусламжтай агаар дахь хүчилтөрөгчийн молекултай нэгдэж озон үүсгэдэг. Газар орчим үүссэн озон нь хүний эрүүл мэнд ялангуяа хүний амьсгалын зам, уушгийг гэмтээх, астам үүсэх ургамал бүрхэвчийг гэмтээх нөлөөтэй байдаг. Нэгэнт агаарт үүссэн озон эргээд азотын исэл (NO)-тэй урвалд орж дахин азотын давхар ислийг бий болгодог.



Иймээс азотын давхар исэл нь агаар мандалд явагддаг фотохимийн урвалд гол үүрэг гүйцэтгэдэг.

Тоос тоосонцор: Хот суурин газрын агаарт янз бүрийн эх үүсвэрээс үүдэлэй тоос тоосонцор байх ба тэдгээрийн аэродимак хэмжээ, химийн найрлага, усанд уусах шинж чанар, гэрлийг шингээх, ойлгох, орчны агаар дахь агууламж зэргээс хамаараад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байдаг. Агаар мандалд 0.001-100 микрометр ширхэглэлийн хэмжээтэй тоос тоосонцор түгээмэл илрэх ба ширхэглэлийн хэмжээ(аэродинамик диаметр)-нээс хамаарсан агууламжын тархалтын гол онцлогийг зурагт үзүүлэв.



Зураг №7. Тоосонцорын аэродинамик хэмжээ, мкм

Азотын давхар исэл: Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали йодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан авахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанилины хүчилтэй харилцан үйлчилж diazonegдлийг үүсгэх бөгөөд тэр нь нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.

Хүхэрлэг хий: Тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд соруулахад шигээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозанилины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлно. Хүхэрлэг хий монитрогийн судалгаагаар хэмжсэн хэмжилт агаарын чанарын стандарт MNS4585:2016 20 минутын хэмжилтын 450 мкг/м³ хүлцэх агууламжаас даваагүй хэмжигдсэн байна.

Нийт тоос: Нийт тоос нь агаарт агуулагдах 100 микрометр хүртэлх ширхэглэлийн хэмжээтэй (аэродинамик эквалиент диаметр) тоос тоосонцорын хэмжээ юм. Агаар дахь нийт тоосны агууламжийг DustTrak8530 зөөврийн автомат багажаар тодорхойлсон. Уг багажийн ажиллах зарчим нь агаарын сорьцыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар соруулан оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн саринал тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй агаар дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдагт үндэслэдэг.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

